



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/75

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 28 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны 03 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор, Засгийн газрын Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нөөцөд 2020-2021 оны тэжээл бэлтгэн нийлүүлэхээр шууд гэрээ байгуулан ажиллаж байгаа "Аж мандалт Ховд" ХХК-д гэрээний дагуу 80 хувийн санхүүжилт болох 29 880 000 төгрөг /хорин есөн сая найман зуун наян мянган/-ийг олгосугай.
2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 29 880 000 сая төгрөгийг аймгийн өвс, тэжээлийн нөөцийн санхүүжилтээс олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.
3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ